

Халхын Түмэнхэн хөндлөн цөөхүр ноёны асуудалд (= Об изучении биографии халхаского Түмэнхэн Сайн-нойон-хана)

Чултэмсүрэн П.¹

¹ Монгольский Национальный архив (Үндэсний төв архив, Нисэхийн Зам, Улан-Батор, Монголия)
научный сотрудник
E-mail: chultemsuren@yahoo.com

© КалмНЦ РАН, 2020
© Чултэмсүрэн П., 2020

Аннотация. В работе раскрываются страницы истории Халхи XVI–XVII вв., описываются события, активное участие в которых принял один из видных государственных и религиозных деятелей Түмэнхэн Сайн-ноён (*Түмэнхэн хөндлөн цөөхүр ноён*) (1558–1640). Отмечается, что это был исторический период, связанный с третьей волной распространения буддизма среди монголов, но и не только: именно в это время в политической истории, экономике и религиозной жизни государств и народов Центральной Азии происходили существенные изменения. В этот период Түмэнхэн Сайн-ноён вместе со своим старшим братом Аватаем приложили немало усилий в распространении учения школы Гелук, в организации возведения буддийских храмов, переводе священных книг.

Ключевые слова: история, Халха, XVI–XVII вв., Түмэнхэн хөндлөн цөөхүр ноён, государственный и религиозный деятель

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Чултэмсүрэн П. Халхын Түмэнхэн хөндлөн цөөхүр ноёны асуудалд // Desertum Magnum: studia historica. 2020. № 2. С.65–69. DOI: 10.22162/2712-8431-2020-10-2-65-69

UDC 94(517)

DOI: 10.22162/2712-8431-2020-10-2-65-69

Regarding the Study of Khalkha Tumenkhen Sain-noyon Khan Biography

Chultemsuren P.¹

¹Mongolian National Archive (National Center archives (Aviation Road,
Ulaanbaatar 11000, Mongolia)

Research Associate

E-mail: chultemsuren@yahoo.com

© KalmSC RAS, 2020

© Chultemsuren P., 2020

Abstract. The article reveals the Khalkha history of the XVI–XVII centuries, describes the events where one of the prominent state and religious leaders Tumenkhen Sain-noyon (1558–1640) took an active part. It is noted that this was a historic period related to the third wave of the spread of Buddhism among Mongols. This also was the time of significant changes in the political history, economics and religious life of the countries and nations of Central Asia. During this period Tumenkhen Sain-noyon with his elder brother Avatai made great efforts to spread the teaching of Geluk, organize the building of Buddhist temples and translate sacred books.

Keywords: history, Khalkha, XVI–XVII centuries, Tumenkhen Sain-noyon, state and religious leader

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Chultemsuren P. Regarding the Study of Khalkha Tumenkhen Sain-noyon Khan Biography. In: *Desertum Magnum: studia historica*. 2020. No. 2. Pp. 65–69. DOI: 10.22162/2712-8431-2020-10-2-65-69

Түмэнхэн хөндлөн цөөхүр ноён нь 1558–1640 оны үед амьдарч байсан Халхын улс төр, шашны томоохон зүтгэлтэн билээ. Өөрөөр хэлбэл XVI зууны сүүлч, XVII зууны дунд үе хүртэлх Халхын түүхийн гол төлөөлөгчийн нэг юм. Тухайн цаг үе нь монгол оронд бурхны шашин гурвантаа дэлгэрч байсан төдийгүй, Төв Азийн улс үндэстнүүдийн улс төр, эдийн засаг, шашин соёлын байдалд ч эрс өөрчлөлт гарсан түүхэн цаг үе байсан.

Энэхүү ээдрээтэй цаг үед Түмэнхэн Сайн ноён, ах Автайн хамт Бурхны шашны Гэлүг багийн ёсыг дэлгэрүүлэхийн тулд идэвхийлэн оролцож, шашны сүм хийд бариулах, ном судар орчуулах үйлсэд хүчин зүтгэж явсан юм. Гэтэл Автай сайн хан эрт нас барж, түүний орыг залгамжилсан Эрээхэй ноён мөн адил үгүй болсноор Түмэнхэн ноён Халхын ноёдыг хэсэг хугацаанд тэргүүлэн, улс төр, шашны байр сууриа бэхжүүлж чадсан юм.

Тэрээр Түшээт хан Гомбодоржийг төрийн хэрэгт оролцох хүртэл халхын ноёдыг тэргүүлж байжээ. Жишээлбэл: Бэрхийн арын булагт цааз тогтооход тэргүүлсэн, 1616 онд түүний нэрэмжит сүмийн өмнө дөрвөн хошууны цааз тогтоож байсан, 1920 он (мичин жил)-ийн долоон хошууны их цаазыг тогтооход Хөндлөн цөөхүр ноён нь Түшээт ханы дараа хоёрдугаар нэр нь бичигдэж байсан зэрэг нь Хөндлөн цөөхүр ноён халхын улс төрд голлох үүрэг гүйцэтгэж байсны жишээ юм. Мөн Түшээт хааны отог, Түшээт хааны эх хатан (тайху)-ны отог Хөндлөн цөөхүр сайн ноёны отгийг их отог хэмээн нэрлэж байсан нь Хөндлөн цөөхүр ноёны ирэмбэ дараа, байр суурь, нөлөө их байсныг давхар нотлож байна.

Халхын ноёдын биеэ биеэсээ өрсөж Түвэдийн шарын шашны тэргүүн Далай лам болон бусад лам хуваргуудад өргөл барьц өргөн, Халхад өөрийн нэр нөлөөгөө батжуулах, дээшлүүлэх бодлого явуулж байсан. Энэхүү ноёдын нэг бол Түмэнхэн хөндлөн Цөөхүр ноён юм.

Зарим сурвалжийн мэдээнд Хөндлөн Цөөхүр ноён Түвэдэд хүрч Далай ламтай уулзсан тухай түүнийг өмгөөлөхөөр Түвэдэд цэрэг авч очсон тухай дурдсан байдаг. Жишээлбэл:

Галданы «Эрдэнийн эрих»-д «... Нэгэн зүйл. Улаан шашин хэмээсэн нь буй. Шар шашны хүмүүн лүгээ тэмцэлдэхэд Түмэнхэн бээр шар шашныг дээдэлж, хамгаалан харилцсаны тулд Тангудын Далай лам түүнийг сайшааж, Сайн ноён цол соёрхож, харьяат аймгийн ардыг цөм гурван хаан лугаа адил түүнийг хүндлэх бөлгөө» хэмээжээ [Галдан 1960: 71].

Халхын Түмэнхэн номун эзэн Сайн ноён ханы уг эхэд: «...Сайн ноён хан Батсүхийн уг эх, хэргэм цолыг байцааваас анхан түшмэл байгуулсан Шамба болбоос Халхын аймгийн хүн, боржигод овогтой Юан Улсын тайзу хааны үр, Халхын Гэрсэнз жалайр хунтайжийн залгамцар. Үүний элэнц өвөг Түмэнхэн угтаа цол Сайн ноён хэмээмүй. Гурван хан лугаа хамт хан хэмээн өргөх бөлгөө» хэмээжээ [МУҮТА.ТБА. ХА-59, Д-1, ХН-29, хуу-13].

Академич Ш. Нацагдорж «... Гавж Эрдэнэпил, Түмэнхэн сайн ноёны тухай бичсэн сонирхолтой өгүүлэлдээ Түмэнхэн бол 1558 онд төрөөд 1640 онд үхжээ. Өндөр гэгээнийг 1640 онд ширээнд залж байхад ная гаруй насалсан хүн байсан. Түмэнхэн Халхаас эн тэргүүн удаа Баруун Зууд очиж Түвэдтэй харилцсан хүн, Харин Автай сайн ханыг Түвэдэд

биеэр очиж Далай ламтай учирсан гэж ерийн үгэнд явдаг нь ташаарсан хэрэг» гэжээ [Нацагдорж 2008: 43]. Энэхүү мэдээнүүдээс харахад Түмэнхэн бол Далай ламтай Түвэдэд хүрч уулзсан. Харин Автай сайн хан бол Түвэдэд хүрч Далай ламтай уулзсан гэдэг эргэлзээтэй байна.

III Далай ламыг Түвэдэд биш Өвөрмонголд ном тавьж явахад Автай сайн хан хүрч очиж уулзсан ажээ. «... 1587 он Мин улсын Шинзун хааны Вэн Ли-гийн арван тавдугаар онд Цахар аймгийн түрүү Түмэн хаан элч илгээж урьсанаар Содномжамц бас Өвөрмонголын зүүн орноор хүрч ном тавин, үлэмж олон шавь хураасан байна. Мөн жилд Халхаас Автай тайж алс холоос морилон ирж золгосонд, Содномжамц түүнд „Очирт номын хаан“ цол өргөмжлөв. Үүнээс үзэхэд шарын шашны нөлөө энэ үед нэгэнтээ дотоод, гадаад Монгол даяар түгэн дэлгэрсэн байна» гэжээ [Яа Хан Ван 1984: 47].

Хэдийгээр ар өвөр Монголд шарын шашин түгэн дэлгэрч байсан хэдийч уламжлалт улааны шашны төлөөлөгчид байр сууриа амар хялбар тавьж өгсөнгүй. Улмаар дотоодын зөрчил тэмцэл хурцтаж, улс орны тусгаар байдлыг тогтворгүй болгов. Энэ нь цаанаа улс төрийн учир шалтгаантай байв.

Үүний тод жишээ бол Түмэнхэн болоод Цогт хунтайжийн зөрчил тэмцэл хурцтаж яваандаа Цогт хунтайж халхаас шахагдан Хөхнуур явах шалтгаан болсон.

Цогт, эхийн хамт Сэтгэшгүй чандмань нэрт зургаан сүм барьж дуусах хүртэл Түмэнхэн ноёнтой төдийлөн тэмцэл, зөрчил байсангүй бололтой. Учир нь:

Цогтын бурхны шашныг тэтгэхийн тулд олон жил хүч хөдөлмөрөө өгч байж байгуулсан зургаан сүмнээ нээлтэд зориулсан гэрэлт хөшөөний бичээст «... Үйзэн тайжийн зургаан хөвгүүн нь

Очир хаан, Дайчин, Елдэн (Илдэн), Цөөхүр, Хошууч, Бодисатв.

Олны дотроос наран саран мэт ном ертөнц хоёроо үлэмж туст Хаан, Цөөхүр хоёрын жаргуулсан цагт

Хошууч тайжийн чин бишрэлт сайн

Мади Тайхал хатан Цогт тайж эх хөвгүүн хоёр

Халдудын зүрхэн нэрт уулын өмнөд эгшээрэгт

Төмөр үхэр жилийн хөхөө сарын арван тавнаас үүдэж

Сэтгэшгүй чандмань тэргүүт зургаан сүмийг

Арван долоон жилийн хойно гал могой жилийн зуны эхэн хөхөө сар дуусгав» гэсэн байдаг.

Энэ шүлэгт: «***Хаан, Цөөхүр хоёрын жаргуулсан цагт***» хэмээн гарч буй нь Хаан гэдэг нь Автай сайн хан, Цөөхүр гэдэг нь Түмэнхэн хөндлөн Цөөхүр ноёныг хэлж байна гэж бид үзэж байна. Цогтын энэ хоёр авга ах бол Бурхны шашныг дэлгэрүүлэх, тэр дундаа шар малгайтны урсгалыг хөхиүлэн дэмжиж байсан хүмүүс юм.

Сүмийн нээлтийг хийж байх энэ цаг үед Халхын ноёдын дунд илтэд улаан, шараар ялгаран үйл ажиллагаа явуулж байсангүй. Харин бүгд л бурханы шашныг дэлгэрүүлэхийн төлөө хүчээ өгч байв. Тиймч учраас гэрэлт хөшөөний бичигт энэ хоёр авга ахынх нь нэрийг магтан дурьдан бичжээ. Гэвч Лигдэн хаанаас нүүр буруулсан өвөрлөгчийн ноёд Сэцэн хан Шолойг түших болсноор халхын ноёдын дотоод зөрчил гарах болсон.

Академич Ш. Нацагдорж, Халхын дотор чухам хэн толгойлон Цогтын эсрэг тэмцсэн нь тодорхойгүй. Халхын ноёдын эвдрэл нилээд хөлтэй зүйл болсон байжээ гэж тэмдэглэжээ. Мөн энэхүү зөрчлийн тухай Х. Пэрлээ «...Олон Сүмийн хөл ба зүүн Рээтү нь дэлхийн 47-р өргөрөг, 102-р уртарлагийн солбилцолын хавилцаа байна. Энэ хавилцаа Онгийн голд өмнө умраас хатгаж орсон мөргөцгүүд дээр дайны чулуун шивээний ор дөрөө байгаа нь тэр нутагт бүддийн шашны улаан малгайтан, шар малгайтны талыг баримтлагч нар болж, Түмэнхэн хөндлөн цөөхүр, Цогт хунтайж нарын талынхны тэмцлийн түүхнээ холбогдох дурсгал болно байх» гэжээ [Пэрлээ 1978: 136].

Халхын Урианхайны Үйзэн ноёны айлтгасан бичигт: «...Өөрийн чинь эцэг Буйма дайчин хошууч бээр Цогт хаан төрөөс урваад шашныг эвдэхүйд Халх, Ойрад хоёрын цэргээр номхотгоход туслалцсан билээ гэж намайг Үйзэн ноёны цолоор болоод засгийн ноёны болгосонд дээр лам хийгээд хоёр ханы элч ба хүүхэд дүү нэр эхлэн элчид бээр эзэнд бараалхаж учраа айлтгахүйд мөнхүү нэр ёсоор учраа айлтгаад бэлэг дээжээ барих нь ийн болой» [Дайчин гүрний 2010: 348] хэмээсэн байдаг.

Дээрх хоёр баримт нь Түмэнхэн болон халхын Урианхайны ноёд Цогт хунтайжтай зөрчилтэй байсныг нотлож байгаа юм.

Түмэнхэн хөндлөн цөөхүр ноён бол XVI зууны эцэс XVII зууны эхэн үеийн Халхын улс төр, шашинд тодорхой үүрэг гүйцэтгэсэн улс төр, шашны зүтгэлтэн байсан юм. Түүний үр хойчис хожим 1725 онд Сайн ноён хан аймгийг байгуулжээ.

Ном зүй

Галдан 1960 — *Галдан*. Эрдэнийн эрих. Улаанбаатар, 1960.

Дайчин гүрний 2010 — Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Зургаадугаар боть. Улаанбаатар 2010.

МУУТА — Монгол Улсын Үндэсний Төв Архив.

Нацагдорж 2008 — *Нацагдорж Ш.* Халхын түүх. Улаанбаатар: Бемби сан, 2008. 383 х.

Пэрлээ 1978 — *Пэрлээ Х.* Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. Улаанбаатар, 1978. 139 х.

Яа Хан Ван 1984 — *Яа Хан Ван*. Далай ламын намтар. Зоригт, Мандах, Хуврун орчуулав. Бээжин: Үндэсний хэвлэлийн хороо, 1984.